



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/81

Сүхбаатар сум

Сургуулийн өмнөх боловсролын сургалтын
үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4, 10.4.6, 10.4.7, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.7, Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4, 11.1.8, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 17 дугаар зүйлийн 17.1.1, Монгол Улсын Боловсрол шинжлэх ухааны сайдын 2021 оны 03 сарын 26-ны А/120 дугаар тушаалын 4 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 25 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын тархалт нэмэгдэж байгаатай холбогдуулан сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагааг 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийг хүртэл хугацаанд зайн сургалтын хэлбэрт шилжүүлсүгэй.

2. Сургалтын үйл ажиллагаа зайн хэлбэрт шилжсэнтэй холбогдуулан хүүхэд хамгааллын ажилд онцгой анхаарч, ахуйн осол, гэмтэл, эрсдэлд орохоос урьдчилан сэргийлж гудамж, хэсгүүдэд хөдөлгөөнт эргүүл гарган, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга М.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ш.ОРГИЛ

